



ДОРНОГОВЬ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ (2018 оны 06 сард)




2018.07.10

www.dornogovi.nso.mn


Дорноговь аймаг
нийгэм, эдийн засгийн байдал
(2018 оны 06 сард)



БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД



926



436

Нийт бүртгэлтэй ажилгүй иргэд



Өмнөх оны
мөн үе

55.7%↓



Өмнөх
Сараас

7.7%↑



164 иргэн ажилд
зуучлагдан оржээ



Хөдөлмөрийн хэлтэст ажил хайж бүртгүүлсэн иргэд 2018 оны эхний хагас жилд 926 болсны 914 (98.7%) нь бүртгэлтэй ажилгүй иргэд, 12 (1.3%) нь ажилтай боловч өөр ажил хайж байгаа иргэд байна.

Нийт ажилгүй иргэдийн 436 (47.1 %) нь эмэгтэйчүүд байна.


Нийт бүртгэлтэй ажилгүй иргэд нь өмнөх оны мөн үеийнхээс 737(55.7%) хүнээр буурч, өмнөх сараас 66(7.7%) хүнээр өссөн байна.

Хөдөлмөрийн хэлтэст 2018 оны эхний 06 сард 1264 иргэн шинээр бүртгүүлж, бүртгэлтэй байсан 164 иргэн ажилд зуучлагдан орж, 93 иргэн ажил идэвхтэй хайхгүй байгаа шалтгаанаар бүртгэлээс хасагдсан байна.

БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД



Бүртгэлтэй ажил хайгч иргэд, боловсролын түвшнээр, 2018 оны 06 сард





ЭРҮҮЛ МЭНД



Дорноговь аймгийн хэмжээнд 2018 оны 06 сард 664 эх амаржиж, 666 хүүхэд шинээр мэндэлжээ. Амаржсан эхийн тоо өмнөх оны мөн үеэс 86(11.5%)-аар буурч, төрсөн хүүхдийн тоо өмнөх оны мөн үеэс 28(4.4%)-аар, 191 хүн нас барсан нь 6(3.2%)-аар тус тус өссөн байна.



Нялхсын эндэгдэл 10 байгаа нь өмнөх оны мөн үеэс 66.7 хувиар өсчээ.



Он гарсаар эхийн эндэгдэл гараагүй




Халдварт өвчний 359 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 128 (26.3%)-оор буурчээ.



Халдварт өвчний тохиолдол буурахад трихоминиаз 4.3 хувь, вирус гепатит 71.4 хувь тэмбүү 22.6 хувь, бусад төрлийн өвчин 63.5 хувиар тус тус буурсан нь голлон нөлөөлжээ.

ЭРҮҮЛ МЭНД

Нас баралт, өвчний шалтгаанаар, хувь. 2018 оны 06 сард





НИЙГМИЙН ДААТГАЛ, ХАЛАМЖ

01

Эрүүл мэнд, нийгмийн даатгалын газрын мэдээллээр нийгмийн даатгалын сангийн орлого 2018 оны эхний 06 сард 16455.2 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 2619.2 (18.9%) сая төгрөгөөр өссөн байна.

02

Нийгмийн даатгалын сангийн орлого 2018 оны эхний 06 сард өмнөх оны мөн үеэс 18.9 хувиар нэмэгдэхэд тэтгэврийн даатгал 1989.2 (23.8%) сая төгрөг, ҮОМШӨ-ний даатгалын сан 331,5 (24.0%) сая төгрөг, тэтгэмжийн даатгал 225.5 (23.8%) сая төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлсөн байна

03

Нийгмийн даатгалын сангийн зарлага 22196.4 сая.төг болж өмнөх оны мөн үеэс 2921.6 (15.2%) сая.төгрөгөөр өссөн байна.

04



Зарлагыг бүтцээр нь авч үзвэл тэтгэврийн даатгалын сангаас 15884.7 (71.6%) сая.төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангаас 3441.3 (15.5%) сая төгрөг, тэтгэмжийн даатгалын сангаас 1238.3 (5.6%) сая.төгрөг, ҮОМШӨ-ний даатгалын сангаас 1265.4 (5.7%) сая.төгрөг, ажилгүйдлийн даатгалын сангаас 366.7 (1.7%) сая төгрөгийг зарцуулжээ.

05

Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын мэдээллээр нийгмийн халамжийн сангаас 2018 оны эхний 06 сард нийгмийн халамжийн сангаас 21761 иргэнд 4050.2 сая төгрөгийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж олгожээ

ГЭМТ ХЭРЭГ

Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, үйлдэгдсэн цагаар



Аймгийн Цагдаагийн газраас ирүүлсэн мэдээгээр оны эхний хагас жилийн байдлаар 293 хэрэг бүртгэгдэж, өмнөх оны мөн үеэс 23(8.7%)-аар буурсан байна.

Өмнөх оны мөн үеэс нийт гэмт хэрэг буурахад олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг 18(72.0%)-аар, хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 3(30.0%)-аар, хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг 2(28.5%)-оор, хүний эрүүл мэндэд хохирол учруулсан гэмт хэрэг 3(3.9%)-аар буурсан нь голлон нөлөөлөв.



Гэмт хэргийн улмаас иргэд, байгууллага, аж ахуйн нэгжид 494.3 сая төгрөгийн хохирол учирсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2521.4(83.6) сая төгрөгөөр буурсан байна. Учирсан хохирлын 328.3(66.4%) сая төгрөг эргэн төлөгдсөн байна.



МӨНГӨ, ЗЭЭЛ

Хадгаламжийн үлдэгдэл, сая.төг



2017 I-VI

68743.9

2018 I-VI

93292.9

Зээлийн өрийн үлдэгдэл, сая.төг



2017 I-VI

186699.9

2018 I-VI

228648.8

-Иргэдийн мөнгөн хадгаламж 93.3 тэрбум төгрөг болж

24.5 тэрбум ↑

- Нэг хадгаламж эзэмшигчдэд 1035.6 мянган төгрөг

3.9 мян.төг ↓

- Нэг хүнд дундажаар 1367.9 мянган төгрөг болж

335.8 мян.төг ↑

- Хадгаламж эзэмшигчийн тоо 90.1 мянган хүн болж

36.2 % ↑

-Зээлдэгчийн тоо 29.7 мянган хүн болж

12.6 % ↑


- Зээлийн өрийн үлдэгдэл 228.6 тэрбум болж

22.5% ↑




МӨНГӨ, ЗЭЭЛ

ЗЭЭЛ, төрлөөр, дүнд эзлэх хувиар, 2018.06-р сард



Зээлдэгчийн тоо, зээлийн төрлөөр, 2018.06-р сард



ТӨСӨВ, САНХҮҮ



2018 оны 06 дугаар сарын байдлаар орон нутгийн төсөвт 13928.2 сая төгрөгийн орлого төвлөрүүлжээ. Төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт 103.4 хувь байна. Өмнөх оны мөн үетэй төсвийн орлогын дүнг харьцуулахад 37.6 хувиар өссөн байна. Аймгийн орон нутгийн төсвийн орлогын 73.9 хувийг татварын, 26.1 хувийг татварын бус орлого бүрдүүлсэн байна.

Орон нутгийн төсвийн
орлого, сая төг

10122.3 13928.2

2017 I-VI

2018 I-VI

Орон нутгийн төсвийн
зарлага, сая төг

25960.6 27313.9

2017 I-VI

2018 I-VI



ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС



Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2018 оны 06-р сард өмнөх сараас 0.6 хувиар өсч, өмнөх оны мөн үеэс 4.5 хувиар өссөн байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2018 оны 06 дугаар сард өмнөх сараас 0.6 хувиар өсөхөд:

хүнсний бараа, ундаа усны бүлэг 1,2 хувь, согтууруулах ундаа, тамхи мансууруулах бодисын бүлэг, 0.4 хувь, гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлэг 0.9 хувь, эм тариа эмнэлэгийн үйлчилгээний бүлэг 0.7 хувь, зочид буудал, зоогийн газар, дотуур байрны үйлчилгээний бүлэг 1.6 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.



Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ өмнөх оны мөн үеэс 4.5 хувиар өсөхөд:

хүнсний бараа, ундаа усны бүлэг 5.2 хувь, согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодисын бүлэг 7.8 хувь, орон сууц, ус цахилгаан, түлшний бүлэг 0.3 хувь, эм, тариа, эмнэлэгийн үйлчилгээний бүлэг 119.6 хувь, тээврын бүлэг 4.1 хувь, амралт, чөлөөт цаг, соёлын барааны бүлэг 9.7 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээний бүлэг 2.6 хувиар тус тус нэмэгдсэн байна.






ХӨДӨӨ АЖ АХУЙ

Бойжиж буй төлийн тоо, 2015-2018 оны 6-р сарын байдлаар, толгой



	2015.I-VI	2016.I-VI	2017.I-VI	2018.I-VI
Бүгд	544952	466863	571231	591946
Ботго	5669	5931	6342	6512
Унага	17733	11609	18331	19003
Тугал	15869	11729	13737	15858
Хурга	248813	236137	283809	292632
Ишиг	236868	201457	249012	257941

Том малын зүй бус хорогдол, 2015-2018 оны 6-р сарын байдлаар, толгой






АЖ ҮЙЛДВЭР



Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2018 оны эхний 06 сард 101390.1 сая төгрөг төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 53218.0 (2.1 дахин) төгрөгөөр өслөө.




Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн 2018 оны эхний 06 сард 133430.9 сая төгрөгт хүрч, өмнөх оноос 40712.9(43.9%) төгрөгөөр өслөө.




АЖ ҮЙЛДВЭР

Аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэлт салбараар



Аж үйлдвэрийн нийт борлуулалт салбараар





АЖ ҮЙЛДВЭР

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэлт, дэд салбараар, оны үнээр, сая төгрөг

Салбар	2016 I-VI	2017 I-VI	2018 I-VI	2017 I-VI 2018 I-VI
	сая.төг			хувь
Дүн	8520.3	48172.1	101390.1	2.1 ²
Уул уурхай олборлох аж үйлдвэр	1994.0	33526.3	48955.6	146.0
Нүүрс олборлолт	1994	33526.3	48955.6	146.0
Бусад ашигт малтмал олборлолт				
Боловсруулах аж үйлдвэр	584.7	10862.5	48457.1	4.5 ²
Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл	386.3	1088.2	631.7	58.0
мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	21.8	678.2	273.2	40.3
сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	52.5	92.4	75.6	81.8
хүнсний бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэл	312.0	317.6	282.9	89.1
Хувцас үйлдвэрлэл	29.8	19.9	26.6	133.7
Гутал үйлдвэрлэл	6.3	7.9	3.2	40.5
Мод, модон эдлэл үйлдвэрлэл	21.6	20.3	39.1	192.6
Машин тоног төхөөрөмжөөс бусад төмөр эдлэл үйлдвэрлэл	3.1	0.2	0.0	
Боловсруулах үйлдвэрийн бусад	137.6	9726.0	47756.5	4.9 ²
Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэлт, усан хангамж	5941.6	3783.3	3977.4	105.1
Цахилгаан, дулаан, уур үйлдвэрлэл	5027.9	2664.0	2933.7	110.1
Ус ариутгал, усан хангамж	913.7	1119.3	1043.7	93.2

2018 оны эхний хагас жилийн байдлаар нийт 171560.9 сая төгрөгийн шинэ барилга, өргөтгөл, шинэчлэлт, их засварын ажил хийсэн нь өмнөх онтой харьцуулахад 5.8 дахин нэмэгдсэн байна.





ТЭЭВЭР

01

Оны эхний 6-р сарын байдлаар ачаа эргэлт 22438.4 мян.тн.км байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс 2315.6 (9.4 %) буурсан байна

02

Тээсэн ачаа 81.6 мян.тн байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс 5.0 (5.8%) буурсан байна

03

Оны эхний 6-р сарын байдлаар зорчигч эргэлт 5572.2 мян.хүн.км байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс 573.3 (11.5%) нэмэгдсэн байна

04

2018 оны 06-р сарын байдлаар зорчигчын тоо 43.4 мян.хүн байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс 3.7 (9.3%) нэмэгдсэн байна

05

Тээврийн салбарын орлого 5486.7 сая төгрөг байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс 84.7 (1.6%)-аар нэмэгдсэн байна



СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙГ ХЭРХЭН АВАХ ВЭ?

Статистикийн лавлах
1900-1212

Статистикийн мэдээллийн
нэгдсэн сан
www.1212.mn

Дорноговь аймгын
Нутгийн
удирдлагын
ордоны 106 тоот

 Статистик мэдээлэл

 @statistic_mn

www.nso.mn сайтын
Хэрэглэгчийн бүртгэлд
бүртгүүлж мэдээлэл авах

